

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/129/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: <a href="mailto:Tserenkhand@audit.gov.mn">Tserenkhand@audit.gov.mn</a> Төгс нотолгоо аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Цэцэгмаа Утас: 99889665 Цахим хаяг: <a href="mailto:tugsnotolgooaudit@gmail.com">tugsnotolgooaudit@gmail.com</a></p>
---------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 24 № 91

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй, өргөн тархсан байна. Үүнд:

- Баян өргөөт малчдын холбоо ТББ-д 4,800.0 мянган төгрөгийг шилжүүлж нүүрс худалдан авсан гэх боловч эд хариуцагчийн тайлангаар орлого аваагүй, нягтлан бодогч орлого авч үлдэгдлээр тайлагнасан,
- Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй байхад ДҮЗОНАЗО ХХК-д 10,097.7 мянган төгрөгийн халаалтын хөлс төлсөн,
- Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх 21,081.3 мянган төгрөгийн өглөгийг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад 9,697.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Х.СЭНДЭРМАА ТАНАА

822505000245

- Санхүүгийн тайлангаарх 12,093.0 мянган төгрөгийн хүнсний материалын өглөг анхан шатны баримтаар нотлогдохгүй, тооцоо нийлсэн аргаар баталгаажуулаагүй,
- Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлээс 1,534.1 мянган төгрөгөөр, хүнсний материалын үлдэгдлийг 219.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагансан,
- Зардлын засгийн ангилал зөрчин мэдээлэл технологийн зардлаас Удмын хишиг ХХК-д 7,480.0 мянган төгрөгийг шилжүүлж, үндсэн хөрөнгө худалдан авсан,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого болон эд хариуцагчийн тайлангаар нүүрсний үлдэгдэлгүй байхад нягтлан бодох бүртгэлээр 9,425.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан,
- Албан хаагчаас 1,900.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралт "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангалын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвийн санхүүжилт 290,498.9 мянган төгрөгөөр, орон нутгаас авах санхүүжилт 55,226.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд хандив тусламжаар 117,000.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 30,000.0 мянган төгрөгийн барилгын дээврийн засвар, 25,997.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг бэлтгэн данс бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 6 зорилт, 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 30 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж 95.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Боловсролын газраас 92.4 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

**Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>186,448,488.80</b>	<b>168,608,143.14</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	77,231,049.80	31,536,204.14
312	Банканд байгаа бэлэн мөнгө	77,231,049.80	31,536,204.14
3121	Төгрөг	77,231,049.80	31,536,204.14
31211	Төрийн сангийн харилцах	77,231,049.80	31,536,204.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>109,217,439.00</b>	<b>137,071,939.00</b>
351	Түүхий эд материал	86,162,477.50	107,200,477.50
35110	Тусгай зориулалттай материал	86,162,477.50	107,200,477.50
354	Хангамжийн материал	23,054,961.50	29,871,461.50
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	8,651,000.00	8,651,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	2,400,000.00	9,425,000.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	950,000.00	741,500.00
35470	Бусад хангамжийн материал	11,053,961.50	11,053,961.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,058,043,722.44</b>	<b>1,126,312,566.36</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,058,043,722.44	1,126,312,566.36
39100	Газар		
392	Биет хөрөнгө	1,013,083,722.44	1,081,352,566.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,222,549,937.95	1,369,549,937.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(426,442,551.52)	(511,867,958.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,896,726.74	282,239,226.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,721,847.87)	(156,464,417.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,358,008.67	133,333,208.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(70,599,916.21)	(85,418,295.99)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	30,336,000.00	30,336,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,625,000.00	9,625,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,387,500.12)	(4,450,000.16)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	14,469,864.80	14,469,864.80
393	Биет бус хөрөнгө	44,960,000.00	44,960,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,960,000.00	44,960,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,244,492,211.24</b>	<b>1,294,920,709.50</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>34,042,422.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	34,042,422.00
413	Өглөг	-	34,042,422.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	868,000.00
4136	Бусад өглөг	-	33,174,422.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	33,174,422.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,244,492,211.24</b>	<b>1,260,878,287.50</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,244,492,211.24	1,260,878,287.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	335,592,682.00	335,592,682.00
51101	Өмч: - төрийн	335,592,682.00	335,592,682.00
51102	- хувийн		
512	Хуримтлагдсан үр дүн	260,723,293.72	277,109,369.98

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	261,386,004.49	260,723,293.72
51220	Тайлант үеийн үр дүн	(662,710.77)	16,386,076.26
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,176,235.52	648,176,235.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,244,492,211.24</u></b>	<b><u>1,294,920,709.50</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,192,394,550.00</b>	<b>2,606,283,978.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	<b>10,000,000.00</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	-	10,000,000.00
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	-	10,000,000.00
110002	Үйл ажиллагааны орлого		
110003	Хөрөнгийн орлого	-	10,000,000.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>110,174,600.00</b>	<b>168,338,678.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	110,174,600.00	168,338,678.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,018,478.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,488,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,530,378.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	99,012,600.00	140,320,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,162,000.00	20,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,082,219,950.00</b>	<b>2,427,945,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,885,948,550.00	2,176,447,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,885,948,550.00	2,176,447,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	196,271,400.00	251,497,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,271,400.00	251,497,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,193,057,260.77</b>	<b>2,589,897,901.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,193,057,260.77</b>	<b>2,589,897,901.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,131,303,149.66	2,576,409,712.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,486,036,599.38	1,770,650,041.06
210101	Үндсэн цалин	904,327,378.75	1,020,231,647.33
210102	Нэмэгдэл	519,303,420.07	678,281,662.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,917,460.03
210104	Урамшуулал	62,405,800.56	68,219,271.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	184,809,600.00	219,010,719.93
210201	Тэтгэврийн даатгал	126,664,300.00	149,026,819.25
210202	Тэтгэмжийн даатгал	14,713,600.00	17,734,838.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,201,800.00	8,866,729.67
210204	Ажилгүйдлийн даатгал	7,201,800.00	8,605,747.13
210205	Эрүүл мэндийн даатгал	29,028,100.00	34,776,585.44
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	179,067,638.89	228,665,376.48
210301	Гэрэл, цахилгаан	14,353,514.89	13,276,170.48
210302	Түлш, халаалт	159,000,174.00	152,429,138.00
210303	Цэвэр, бохир ус	5,713,950.00	62,960,068.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	8,745,900.00

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210401	Бичиг хэрэг	-	843,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	7,366,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	536,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>63,414,042.00</b>	<b>161,631,160.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	63,414,042.00	161,631,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,840,600.00</b>	<b>19,105,436.00</b>
210604	Урсгал засвар	15,840,600.00	19,105,436.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,498,223.30</b>	<b>15,791,125.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,990,600.00	4,488,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,507,623.30	11,303,025.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>181,636,446.09</b>	<b>152,809,953.27</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,440,300.00	14,761,097.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,462,100.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,734,046.09	138,048,856.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,754,111.11</b>	<b>13,488,189.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,390,950.00</b>	<b>6,845,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,980,650.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,410,300.00	6,845,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,363,161.11</b>	<b>6,642,589.52</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,363,161.11	6,642,589.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(662,710.77)</b>	<b>16,386,076.26</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(662,710.77)</b>	<b>16,386,076.26</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,082,219,950.00</u></b>	<b><u>2,435,963,778.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>8,018,478.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	8,018,478.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,018,478.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,488,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,530,378.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,082,219,950.00</b>	<b>2,427,945,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,885,948,550.00</b>	<b>2,176,447,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,885,948,550.00	2,176,447,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>196,271,400.00</b>	<b>251,497,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,271,400.00	251,497,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,066,490,412.68</u></b>	<b><u>2,451,071,123.66</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,066,490,412.68</b>	<b>2,451,071,123.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,003,238,851.57</b>	<b>2,374,156,134.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,486,036,599.38</b>	<b>1,770,650,041.06</b>
210101	Үндсэн цалин	904,327,378.75	1,020,231,647.33
210102	Нэмэгдэл	519,303,420.07	678,281,662.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,917,460.03
210104	Урамшуулал	62,405,800.56	68,219,271.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>184,809,600.00</b>	<b>219,010,719.93</b>

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210201	Тэтгэврийн даатгал	126,664,300.00	149,026,819.25
210202	Тэтгэмжийн даатгал	14,713,600.00	17,734,838.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,201,800.00	8,866,729.67
210204	Ажилгүйдлийн даатгал	7,201,800.00	8,605,747.13
210205	Эрүүл мэндийн даатгал	29,028,100.00	34,776,585.44
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>179,067,638.89</b>	<b>194,855,210.48</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,353,514.89	15,005,770.48
210302	Түлш, халаалт	159,000,174.00	171,007,650.00
210303	Цэвэр, бохир ус	5,713,950.00	8,841,790.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59,083,790.00</b>	<b>73,485,540.00</b>
210502	Хоол, хүнс	59,083,790.00	73,485,540.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,840,600.00</b>	<b>50,000,000.00</b>
210604	Урсгал засвар	15,840,600.00	50,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,498,223.30</b>	<b>17,441,125.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,990,600.00	4,488,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,507,623.30	12,953,025.48
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,902,400.00</b>	<b>48,713,497.19</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,440,300.00	34,784,897.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,462,100.00	13,928,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>63,251,561.11</b>	<b>76,914,989.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,888,400.00</b>	<b>70,272,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,478,100.00	63,426,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,410,300.00	6,845,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,363,161.11</b>	<b>6,642,589.52</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,363,161.11	6,642,589.52
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,729,537.32</u></b>	<b><u>(15,107,345.66)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>18,317,500.00</b>	<b>30,587,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18,317,500.00</b>	<b>30,587,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>18,317,500.00</b>	<b>30,587,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,317,500.00	30,587,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(18,317,500.00)</u></b>	<b><u>(30,587,500.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(2,587,962.68)</b>	<b>(45,694,845.66)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>79,819,012.48</b>	<b>77,231,049.80</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>77,231,049.80</b>	<b>31,536,204.14</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	261,386,004.49	1,245,154,922.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	261,386,004.49	1,245,154,922.01
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(662,710.77)	(662,710.77)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	260,723,293.72	1,244,492,211.24
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	260,723,293.72	1,244,492,211.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	260,723,293.72	1,244,492,211.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,386,076.26	16,386,076.26
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,592,682.00	648,176,235.52	277,109,369.98	1,260,878,287.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,560,759,900.00	2,481,658,623.66	79,101,276.34	96.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,560,759,900.00	2,481,658,623.66	79,101,276.34	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,486,087,500.00	2,404,743,634.14	81,343,865.86	96.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,815,999,700.00	1,770,650,041.06	45,349,658.94	97.5
210101	Үндсэн цалин	1,157,134,500.00	1,020,231,647.33	136,902,852.67	88.2
210102	Нэмэгдэл	610,665,800.00	678,281,662.49	(67,615,862.49)	111.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,917,460.03	(3,917,460.03)	-
210104	Урамшуулал	48,199,400.00	68,219,271.21	(20,019,871.21)	141.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,999,700.00	219,010,719.93	7,988,980.07	96.5
210201	Тэтгэврийн даатгал	154,360,000.00	149,026,819.25	5,333,180.75	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	18,159,700.00	17,734,838.44	424,861.56	97.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,080,000.00	8,866,729.67	213,270.33	97.7
210204	Ажилгүйдлийн даатгал	9,080,000.00	8,605,747.13	474,252.87	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	36,320,000.00	34,776,585.44	1,543,414.56	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,692,900.00	194,855,210.48	14,837,689.52	92.9
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	15,005,770.48	2,994,229.52	83.4

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210302	Түлш, халаалт	185,025,700.00	171,007,650.00	14,018,050.00	92.4
210303	Цэвэр, бохир ус	6,667,200.00	8,841,790.00	(2,174,590.00)	132.6
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>83,531,200.00</b>	<b>73,485,540.00</b>	<b>10,045,660.00</b>	<b>88.0</b>
210502	Хоол, хүнс	83,531,200.00	73,485,540.00	10,045,660.00	88.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>50,324,000.00</b>	<b>50,000,000.00</b>	<b>324,000.00</b>	<b>99.4</b>
210604	Урсгал засвар	50,324,000.00	50,000,000.00	324,000.00	99.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,025,700.00</b>	<b>27,725,572.67</b>	<b>300,127.33</b>	<b>98.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,488,100.00	4,488,100.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,537,600.00	23,237,472.67	300,127.33	98.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,514,300.00</b>	<b>69,016,550.00</b>	<b>2,497,750.00</b>	<b>96.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,585,500.00	55,087,950.00	2,497,550.00	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,928,800.00	13,928,600.00	200.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>74,672,400.00</b>	<b>76,914,989.52</b>	<b>(2,242,589.52)</b>	<b>103.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>74,672,400.00</b>	<b>70,272,400.00</b>	<b>4,400,000.00</b>	<b>94.1</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,826,800.00	63,426,800.00	4,400,000.00	93.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,845,600.00	6,845,600.00	-	100.0
<b>26</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>6,642,589.52</b>	<b>(6,642,589.52)</b>	<b>-</b>
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,642,589.52	(6,642,589.52)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,560,759,900.00</b>	<b>2,481,658,623.66</b>	<b>79,101,276.34</b>	<b>96.9</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,212,346,700.00</b>	<b>2,176,447,500.00</b>	<b>35,899,200.00</b>	<b>98.4</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,212,346,700.00	2,176,447,500.00	35,899,200.00	98.4
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>265,290,000.00</b>	<b>251,497,800.00</b>	<b>13,792,200.00</b>	<b>94.8</b>
132001	Орон нутгийн төсвөөс	265,290,000.00	251,497,800.00	13,792,200.00	94.8
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>83,123,200.00</b>	<b>53,713,323.66</b>	<b>29,409,876.34</b>	<b>64.6</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,488,100.00	4,488,100.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	3,530,400.00	3,530,378.00	22.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	75,104,700.00	45,694,845.66	29,409,854.34	60.8
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>77,231,049.80</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>31,536,204.14</b>		

**ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

**3.1 Аудитын залруулга**

Аудитаар 77,700.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 2 алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, тайлагнаж ирснийг баталгаажуулав.

Залруулсан алдаа

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,  
ГАА-2026/129/НА-СТА-ТШЗ

### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд түлш халаалтын зардлыг 43,675.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Санхүүгийн тайлангийн өглөгийн эцсийн үлдэгдэл 34,042.4 мянган төгрөгийг хасах утгатай тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Залруулагдаагүй нийт 70,607.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй өргөн тархсан тул "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 70,607.5 мянган төгрөгийн 11 зөрчил илэрснээс 6,700.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 54,674.4 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 9,233.1 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлээ.

### 3.2 Төлбөрийн акт

1. Баян өргөөт малчдын холбоо ТББ-д 4,800.0 мянган төгрөгийг шилжүүлж нүүрс худалдан авсан гэх боловч нярав бодитоор орлого аваагүй, нягтлан бодогч орлого авч үлдэгдлээр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант онд 1 албан хаагчаас 1,900.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### 3.3 Албан шаардлага

1. Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй байхад "ДҮЗОНАЗО" ХХК-д 10,097.7 мянган төгрөгийг халаалтын зардалд төлсөн, тайлант оны эцэст 21,081.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасныг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад 9,697.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эд хариуцагчийн тайлангаар түлш, шатах тослох материалын үлдэгдэлгүй байхад нягтлан бодох бүртгэлд 9,425.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайланд тусгасан хоол, хүнсний материалын өглөг 12,093.0 мянган төгрөгийг анхан шатны баримтаас хөөн шалгахад нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-т "бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авч, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захирал Х.Сэндэрмаад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авч, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч Г.Мөнх-Эрдэнэд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлээс 1,534.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-г заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийг стандарт, журам, зааврын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргах байх.

#### **Хоёр. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Няравын тайлангийн хүнсний материалын эцсийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд 219.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-г заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийг стандарт, журам, зааврын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан гаргаж байх.

#### **Гурав. Баталсан бүтэц орон тоотой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 35,220.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан зардлын хүрээнд зарцуулах.

#### **Дөрөв. Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Зардлын засгийн ангилал зөрчин мэдээлэл технологийн зардлын төсвөөс Удмын хишиг ХХК-аас 7,480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал "Ангилал шинэчлэн батлах тухай" гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Баталсан зардлын хүрээнд зарлага гаргах.

#### **Тав. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Тус сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөл байгуулаагүй, хүнсний хангамж, үйлчилгээтэй холбоотой сургалт, үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын дүн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримтгүй хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/140 дүгээр тушаалын хавсралт" 2.2-т "Гэрээний хэрэгжилтийг Боловсролын ерөнхий хуулийн 34.2-т заасан сургууль, цэцэрлэгийн зөвлөл, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 8.1-т заасан орон тооны бус "Хяналтын зөвлөл" хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд 1-2 удаа хөндлөнгийн хяналт хийх, мөн хуулийн 10.2.5-д заасан журмаар үнэлгээ өгч, дүгнэлт гаргана", 4.5.1-т "хүүхдийн хоолны үйлчилгээг эцэг эх, асран хамгаалагч, хамгаалагч, харгалзан дэмжигчдэд танилцуулах үйл ажиллагааг орон тооны бус "Хяналтын зөвлөл"-тэй хамтран зохион байгуулах, гарсан санал хүсэлтэд үндэслэн улирал бүр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ", 5.5-т "Сургалтын байгууллагын хүнсний хангамж, үйлчилгээтэй холбоотой сургалт, үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын дүн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримтыг байгууллагын архивд хадгална" гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөл байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛЭЛ, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*(мянган төгрөгөөр)*

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль	Санхүүгийн тайлангийн өглөгийн эцсийн үлдэгдэл 34,042.4 мянган төгрөгийг хасах утгатай тайлагнасан.	1	34,042.4			1	34,042.4	1	34,042.4	-	-	-	-
	Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд түлш халаалтын зардлыг 43,675.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	43,675.7			1	43,675.7	1	43,675.7				
<b>ДҮН</b>		<b>2</b>	<b>77,700.1</b>			<b>2</b>	<b>77,700.1</b>	<b>2</b>	<b>77,700.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*(мянган төгрөгөөр)*

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		ХХБайгууллагад		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1		3	4	5	6	7	8	9	10	11	12	
	Баян өргөөт малчдын холбоо ТББ-руу 4,800.0 мянган төгрөгийг шилжүүлж нүүрс худалдан авсан гэх боловч нярав бодитоор орлого аваагүй, нягтлан бодогч орлого авч үлдэгдлээр тайлагнасан	1	4,800.0	1	4,800.0	-	-	-	-	-	-	
Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургууль	Тайлант онд 1 албан хаагчаас 1,900.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй байна.	1	1,900.0	1	1,900.0	-	-	-	-	-	-	
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн тушаалаар едөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 35,220.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	0	-	-	-	-	-	1	0	-	-
	Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдэлгүй байхад "ДҮЗОНАЗО" ХХК-д 10,097.7 мянган төгрөгийг халаалтын зардалд төлсөн, тайлант оны эцэст 21,081.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасныг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад 9,697.7 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	33,156.4	-	-	1	33,156.4	-	-	-	-	-
	Тайлант онд 12,093.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй байна.	1	12,093.0	-	-	1	12,093.0	-	-	-	-	-

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

Эд хариуцагчийн тайлангаар бараа материалын түлш, шатах тослох материалын үлдэгдэлгүй байхад нягтлан бодох бүртгэлд 9,425.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан	1	9,425.0	-	-	1	9,425.0	-	-	-	-
Эд хариуцагчийн хүнсний материалын зарлага нягтлан бодох бүртгэлээс 1534.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	1,534.1	-	-	-	-	1	1,534.1	-	-
Няравын тайлангийн хүнсний материалын эцсийн үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд 219.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	219.0	-	-	-	-	1	219.0	-	-
Тус сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөл байгуулаагүй, хүнсний хангамж, үйлчилгээтэй холбоотой сургалт, үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын дүн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримт байхгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авсан	1	0	-	-	-	-	1	0	-	-
Зардлын засгийн ангилал зөрчин мэдээлэл технологийн зардлаас Удмын хишиг ХХК-с 7,480.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авч төлбөрийг төлсөн	1	7,480.0	-	-	-	-	1	7,480.0	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авч, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн	2	-	-	-	2	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>70,607.5</b>	<b>2</b>	<b>6,700.0</b>	<b>5</b>	<b>54,674.4</b>	<b>5</b>	<b>9,233.1</b>	<b>-</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөжөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1					1	
	<b>НИЙТ</b>		<b>1</b>					<b>1</b>	